

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

/ Орон нутгийн өмчийн газар 2024 оны хагас жил /

2024-06-25

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
1	2.3.7. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	1. Төрийн албан хаагчдад монгол бичгийн сургалт явуулж, "Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	2021 - 2024	20	Монгол бичгийн хичээл заахад зориулж 160000 төгрөг.	60	Орон нутгийн өмчийн газрын албан хаагчид Төрийн албан хаагчид зориулсан Монгол бичгийн анхан шатны богино хугацааны цахим сургалтад амжилттай хамрагдаж сертификат эзэмшсэн бөгөөд Монгол бичгийн дунд хугацааны танхимын сургалтыг долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт Монгол хэл бичгийн мэргэшсэн багш доктор, профессор С.Дорждуламрагчаагаар заалгаж байгаа ба албан хаагчид бүрэн хамрагдаж байна. Тухайн багштай гэрээ байгуулан ажиллаж байгаа болно. Мөн бие даан үндэсний монгол бичгээр бичих, унших чадвараа сайжруулж байна.	70%
2		2. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хэрэг хөтлөлтийг Монгол хэл, бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангуулах	2022 - 2024	0		27	Тус газар нь албан хэрэг хөтлөлийг Монгол бичгээр хөтлөх ажлын хүрээнд байгууллагын бүх албан хаагчдад Монгол бичгийн мэдлэг олгох танхимын сургалтыг долоо хоногын мягмар, пүрэв гарагуудад Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн Монгол хэл, бичгийн багш, доктор, профессор С.Дорждуламрагчаа багшаар заалгаж байна. Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албаны компьютерт үндэсний монгол бичгийн программ суулгаж албан бичгийг хос бичгээр боловсруулан холбогдох газарт хүргүүлж байна.	70%
3		3. Албан байгууллага,	2021 - 2024	25		75	Албан байгууллагын өрөө тасалгааны хаяг болон мэдээллийн самбарыг Монгол болон крилл бичгээр бичиж	70%


		аж ахуйн нэгж болон нийтийн эзэмшлийн талбай, гудамжны хаягийг монгол бичгээр бичиж байрлуулах				байршуулсан		
3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ								
4	3.1.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1. Удирдлагын багийг чадавхжуулах замаар үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх	2021 - 2024			100	1. Аймгийн Орон нутгийн өмчит болон Төрийн өмчит 18 хуулийн этгээдийн 32 албан хаагчид 2023 оны 02 дугаар сарын 09-10-ний өдрүүдэд "Компаний засаглалын үндэсний зөвлөл"-ийн газартай хамтран компаний засаглалын сертификаттай сургалтыг зохион байгуулсан. 2024 онд тус сургалтад хамрагдах албан хаагчдын судалгааг авч байна. 2. Эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтран 2024 оны 05 сарын 09-ны өдөр сумдад дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨААТҮГ-ын удирдлага, удирдах ажилтнуудад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тэдгээрийн өнөөгийн байдал, хэрхэн төрийн хөрөнгийн үр ашигтай ашиглах, ашгийн түвшинг нэмэгдүүлэх, цаашид анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулсан.	70%
5		2. Санхүүгийн сахилга, хөрөнгийн ашиглалтыг сайжруулснаар алдагдлыг бууруулах	2021 - 2024			20	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2023 оны санхүүгийн тайланг Аудитын байгууллага 2024 оны 5 сард баталгаажуулж дууссан. 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, гэрээний хэрэгжилт, үйл ажиллагааны тайланг ажлын хэсгээр хэлэлцэн аймгийн Засаг даргын хуралдаанд таницуулан шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлээд байна.	70%
6	3.1.2. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй	2. Төсөв, санхүүгийн цахим систем	2021 - 2024			25	2023 оны 01 сараас эхлэн байгууллагын төлбөрийн гүйлгээ /finance.gov.mn / цахим системд шилжин өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж	90%

	болгож, сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.	нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх					байна. Мөн тухайн оны 4 дүгээр сараас эхлэн finance.gov.mn ситемээр оруулсан гүйлгээ санхүүгийн cts программ руу хөрвөдөг болсон нь тайлан мэдээ гаргахад хялбар болсон. Төрийн аудитын газраас тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хяналт, шалгалт зохион байгуулж илэрсэн зөрчлийг, хурлын тэмдэглэлд тусган, цаашид байгууллагын батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг албан хаагчдад мэдэгдэж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын төсөв, санхүүгийн холбогдох мэдээллийг shilendans.gov.mn сайтад тухай бүр байршуулан ажиллаж байна.	
4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ								
7	4.1.2. Төрийн байгууллагын ажиллах нөхцөл, техник технологийг сайжруулна.	2. "Төрийн албан хаагчийн ёс зүй, чадавхжуулах сургалт, арга хэмжээг үе шаттай зохион байгуулах "	2021 - 2024	50 5		100 70	Байгууллагын Ёс зүйн дэд хороог газрын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Ёс зүйн хорооны гишүүнээр ажиллаж байсан албан хаагч өөр байгууллагад шилжин томилогдсон тул албан хаагчдын хурлаар шинээр томилогдох гишүүнийг хэлэлцэн, газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний А/24 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Ёс зүйн сургалт зохион байгуулах хүсэлтээ Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь салбарт хүргүүлсэн. Төрийн.Газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/10 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр (2022-2026)-ийг батлуулан хэрэгжилтийг хангах хүрээнд тус газрын 2024 оны хүний нөөцийн сургалтын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Монгол улсын Засгын газрын тэтгэлгээр 1 албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2024-03-11 зохион байгуулсан цахим сургалт, 2024.04.29-2024.05.06-	70%

						<p>ны хооронд зохион байгуулагдсан танхимын сургалт, Авлигатай тэмцэх газраас 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр танилцуулах, Авлигын гэмт хэргийн талаар, Хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах" талаарх танхимын сургалт, Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног болгон зохион байгуулж байгаа 7:4:10 сургалт, мөн долоо хоногийн мягмар пүрэв гарагт мэргэжлийн багшаар үндэсний монгол бичгийн сургалтад тус тус хамрагдаж байна. Төрийн албан хаагчид зориулсан Монгол бичгийн анхан шатны богино хугацааны цахим сургалтад амжилттай хамрагдаж сертификат эзэмшсэн бөгөөд Монгол бичгийн дунд хугацааны танхимын сургалтыг долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт Монгол хэл бичгийн мэргэшсэн багш доктор, профессор С.Дорждуламрагчаагаар заалгаж байгаа ба албан хаагчид бүрэн хамрагдаж байна.</p>	
10		<p>1. Аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</p>	2021 - 2024	0	100	<p>Газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/10 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр (2022-2026)-ийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн дагуу Монгол улсын Засгын газрын тэтгэлгээр 1 албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулж байна. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх аргачлалын дагуу үнэлэн 2024 оны 1 дүгээр улиралд 5 албан хаагчид 2,893,190 төгрөгийн урамшуулал, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу 5 хөдөө орон нутгийн урамшуулалыг 2 албан хаагчид 14,030,000 төгрөг тус тус олгосон. Аймгийн 2023 оны жилийн эцсийн хөрөнгийн нэгдсэн тайлан мэдээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тогтоосон хугацаанд чанартай гаргаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлаар батлуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тушаасан 1 албан хаагчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон. Мөн хөдөлмөрийн дотоод журмын</p>	90%

						дагуу шинээр хүүхэдтэй болсон 2 албан хаагчид тус бүр 300000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын 0-18 насны хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, аймгийн Угсаатны зүйн музейг үзүүлэн гар зургын уралдаан зохион байгуулж, байгууллагын зүгээс бэлэг гардуулсан. Уг арга хэмжээнд 1000000 төгрөг зарцуулсан. Мөн 1 албан хаагчид жирэмсний амралт, 1 албан хаагчид хүүхэд асрах чөлөөг холбогдох хуулийн дагуу олгож нийгмийн баталгааг нь хангаж ажилласан.		
11		2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, орон сууцны нөхцөлийг сайжруулах	2021 - 2024	2.5		30	Энэ онд амины орон сууц барьсан, орон сууцанд шинээр орсон албан хаагч байхгүй бөгөөд дэмжлэг хүссэн хүсэлт ирээгүй болно.	100%
12	4.2.2. Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэж чадавхжуулна.	1. Төрийн албан хаагчдыг Засгийн газрын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдалтыг нэмэгдүүлэх	2021 - 2024	0			Засгийн газрын тэтгэлэгт сургалтад 1 албан хаагч хамрагдаж байна. Гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан албан хаагч байхгүй болно.	100%
13		2. Төрийн албан хаагчдыг үе шаттай мэргэшүүлэх сургалтад хамруулах	2021 - 2024	12.2		90	Байгууллагын 1 албан хаагч дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна.	100%
14	4.2.4. Авлига, ашиг сонирхлын	1. Авлигатай тэмцэх үндэсний	2021 - 2024	71		85	Аймгийн 2024 оны Авлигын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан газрын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигатай тэмцэх	70%

<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотой төлөвлөн, хэрэгжүүлж шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлнэ.</p>	<p>хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах</p>					<p>газраас 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр танилцуулах, Авлигын гэмт хэргийн талаар, Хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах” талаарх танхимын сургалтад 3 албан хаагч хамрагдаж албан хаагчдад холбогдох мэдээллийг танилцуулсан. Тус газрын 3 албан хаагч Хөрөнгө орлогын мэдүүлгээ тухай бүр шинэчлэн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд оруулж байна. “Шудрага ёс, хөгжил дэвшил” мэдээллийн самбарт холбогдох мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байрлуулж байна. 2023 оны 01 сараас эхлэн байгууллагын төлбөрийн гүйлгээ /finance.gov.mn/ цахим системд шилжин өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж байна. Мөн /finance.gov.mn/ ситемээр оруулсан гүйлгээ санхүүгийн /cts/ программ руу хөрвөдөг болсон нь тайлан мэдээ гаргахад улам хялбар болсон. Байгууллагын төсөв, санхүүгийн холбогдох мэдээллийг /shilendans.gov.mn/ сайтад тухай бүр байршуулан ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--

БИЕЛЭЛТ НЭГТГЭН ГАРГАСАН : ХУУЛЬ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
 АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН  /Д.БОРХҮҮ/